



БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2018/2  
[www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

**www.1212.mn**

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.

Monstat ezStat  
аппликейшн

1900-1212  
Лавлах утас

@statistic\_mn

Статистик  
мэдээлэл

Вндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН

Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ

## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	11
I. 2 Хөдөлмөр.....	12
I. 3 Нийгмийн халамж.....	13
I. 3 Нийгмийн даатгал.....	13
I. 4 Эрүүл мэнд .....	14
I. 6 Гэмт хэрэг .....	14
II.3 Үнэ.....	16
II.7 Аж үйлдвэр.....	21
II.14 Мал аж ахуй.....	22

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  -  $t$  тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

$t$  - тайлан үе

$o$  - суурь үе

$p_{it}$  - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## I. Нийгмийн үзүүлэлт




### I.1 Хүн ам

2018 оны 2-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 167 хүүхэд, нас барсан 51 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 13 буюу 7.7 хувиар, нас баралт 9 буюу 17.6 хувиар тус тус өсжээ.

**Зураг I.1.2**


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



2-р сарын байдлаар 191 хүн шилжин ирж, 200 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 34 буюу 16 хувиар, шилжин явсан хүн 100 буюу 34 хувиар тус тус буурсан байна.

**Зураг I.1.3**

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



### I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгч иргэн 1004 болсны 489 нь эмэгтэй байна. Ажил хайгч иргэдийн 0.3 магистр, докторын, 16.5 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.6 хувийг тусгай мэргэжлийн дунд, 3.8 хувийг техникийн болон мэргэжлийн, 60.2 хувийг бүрэн дунд боловсролтой, 11.9 хувийг суурь боловсролтой, 2.6 хувийг бага боловсролтой, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

**Зураг I.2.1**


Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 13.4 хувийг 15-24 насны, 32.8 хувийг 25-34 насны, 24.4 хувийг 35-44 насны, 21.5 хувийг 45-54 насны, 5.7 хувийг 55-59 насны, 2.2 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

**Зураг I.2.2**

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



## I.3. Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны 2-р сарын байдлаар 5558 хүн 753.4 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 67.8 сая.төг буюу 9.9 хувиар өсч харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 709 хүн хамрагдаж 270.5 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 0.9 сая.төг буюу 0.3 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2018 оны 2-р сарын байдлаар 3126 хүн хамрагдсаны 36.7 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 11.3 хувь ахмад

настан, 1.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 50.2 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 289.1 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 124.1 сая.төг буюу 75.2 хувиар өссөн байна.

### Нийгмийн халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны 2-р сарын байдлаар 1457.6 сая төгрөг, зарлага 5609.8 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 282.7 сая төг буюу 16.2 хувиар буурч, зарлага 156.1 сая төг буюу 2.9 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 282.7 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлогогүй байгаа нь голлон нөлөөлсөн байна. Харин тэтгэврийн даатгалын сангийн орлого 158.7 сая.төг буюу 15.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 0.7 сая.төг буюу 2.9 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 156.1 сая.төг буюу 2.9 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сан 478.9 сая.төг буюу 9.9 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 24 сая.төг буюу 15.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.




### I.4 Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд 2018 оны 2-р сарын байдлаар 146 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 148 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 11 буюу 8.1 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 11 буюу 8 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.4.1

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,



Нялхасын э байдлаар г



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2018 оны 2-р сарын байдлаар 60 болж, өмнөх оны мөн үеийнхээс 53 тохиолдол буюу 47 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 25 буюу 41 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 25 буюу 41 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд




### I.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 2 сарын байдлаар 52 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 7 хэргээр буюу 11.9 хувиар буурсан байна.

Зураг I.6.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг




Хэргийн өнгөөр нь авч үзвэл:

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдэж 6 дахин
- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1 дахин
- Залилах гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 дахин өссөн байна.
- Хулгайлах гэмт хэрэг 25 бүртгэгдэж 9 хэргээр буюу 36 хувиар
- Мал хулгайлах хэрэг 2 бүртгэгдэж 8 хэргээр буюу 80 хувиар
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдэж 2 хэргээр буюу 40 хувиар
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг бүртгэгдээгүй буюу 1 дахин
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15 бүртгэгдэж 3 хэргээр буюу 16.7 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас нийт иргэд , аж ахуй нэгж байгууллагад 98.7 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 78.5 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 7.5 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан .

**Зураг I.6.2**

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 2-р сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 8 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 27.2 хувиар буурсан байна.

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 17 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 11, бусад хэрэгийн улмаас ,1 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар буурсан байна.

**Зураг I.6.3**

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн 2-р сарын байдлаар



2018 оны 2-р сарын байдлаар 1596 зөрчилд 70237.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 76 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 7.3 хувиар буурсан байна. Захиргааны журмаар 12 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 46 иргэн байна.



## II. Эдийн засгийн үзүүлэлт

### II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2018 оны 2-р сарын байдлаар 9293.8 сая төгрөг, зарлага 7586.4 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 1707.4 сая төгрөгний эерэг гарлаа.

**Зураг II.1.1**


Аймгийн төсвийн орлого, зарлага сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 35.6 хувийг татварын орлого, 4 хувийг татварын бус орлого, 59.6 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2018 оны 2-р сарын байдлаар 7586.4 сая.төг болоход 78 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 14.5 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

**Зураг II.1.2**

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт өр 162.5 сая, нийт авлага 1.1 сая төгрөг байна. Цалин, НДШ-ийн өр 56.4 сая, тогтмол зардлын өр 76.0 сая, эмийн өр 12.0 сая, бусад зардлын өр 18.1 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр 36.2 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.




**II.3 Үнэ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2018 оны 2-р сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 3.2 хувиар, сарын эхнээс 1.8 хувиар, өмнөх сарынхаас 1.1 хувиар өссөн байна.

**Зураг II.3.1**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2018 II сар, (өмнөх сар=100%)



**Хүснэгт II.3.1**

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2015-XII=100хувь)


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018 II 2017 II	2018 II 2017 XII	2018 II 2018 I
Ерөнхий индекс	100.0	103.2	101.8	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	106.4	103.9	102.4
Салгууруулах ундаа, тэмх	3.2	102.5	101.6	100.0
Хувцас, бас, бараа, гутал	16.1	98.4	100.6	100.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	102.0	100.2	100.0
Гэрэхүйн тавилга, бараа	4.7	101.9	100.2	100.0
Эм тарма, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	101.5	100.2	100.0
Тээвэр	12.2	109.3	105.1	104.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.6	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.1	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	109.5	102.2	100.0

**II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ /жич: Шүлхий өвчинтэй холбоотойгоор 2-р сард мал худалдаалаагүй/**

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2018 оны 1 сарын байдлаар адууны шир 15.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 23.5 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 32.5 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны дэл 42.9 хувиар өссөн бол үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 10.5 хувиар, 2.3 метрээс дээш урттай шир 10.3 хувиар адууны шир 57.1 хувиар буурсан байна.

**II.5 Малын дундаж үнэ**

2018 оны 1 сарын байдлаар тэмээ 950.0 мян.төг, адуу 597.0 мян.төг, үхэр 705.0 мян. төг, хонь 100.0 мян.төг, ямаа 75.0 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс ямаа 5.1 хувь, хонь 9.1, үхэр 13.4 хувь, адуу 0.8 хувь хувиар тус тус буурсан бол тэмээ 23.9 хувиар өссөн байна.




**II.6 Аж үйлдвэр**

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны 2-р сарын байдлаар 924.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1573.8 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 4.3 хувиар өсч, борлуулалт 24.3 хувиар буурсан байна. Өмнөх оноос борлуулалт буурсан шалтгаан нь аймгийн хэмжээнд үйлдвэрлэлт явуулалдаг Хангайн гурил ХХК, Орхон мандал ХХК үйлдвэрлэлт байхгүй, ИНТОСЭ ХХК гурилын үйлдвэр үйлдвэрлэлт урьд оноос эрс бага

2017 онд гантай байснаас ургац алдаж будаа муутай үйлдвэрлэлт муу байгаас шалтгаалж байна.

**Зураг II.6.1**

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт




**II.14 Хөдөө аж ахуй  
Зүй бусын хорогдол**

Том малын зүй бусын хорогдол 2018 оны 2 сарын байдлаар 21.5 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 15.1 мян.толгой малаар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 2.1 мянга, үхэр 4.9 мянга, хонь 3.7 мянга, ямаа 7.5 мянга оны эхний малын 0.6 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 61.1 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Могод сум 20.8 хувь, Орхон сум 18.2 хувь, Бүрэгхангай сум 14.6 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Хорогдсон хээлтэгч 1.4 мянган толгой болж өмнөх оны мөн үеийнхээс ижил өсөлттэй байна.

**Зураг II.14.2**

Том малын зүй бусын хорогдол



**Зураг II.14.1**

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 8 сарын байдлаар, толгой




## I.I ХҮН АМ

## Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам			2017 2016	Эрэгтэй			2017 2016	Эмэгтэй			2017 2016
	2015	2016	2017		2015	2016	2017		2015	2016	2017	
Баян-Агт	3052	3119	12616	102.2	1550	1583	6125	102.1	1502	1536	6491	102.3
Баяннуур	1868	1818	3218	97.3	983	969	1632	98.6	885	849	1586	95.9
Бугат	2182	2241	1861	102.7	1132	1187	998	104.9	1050	1054	863	100.4
Булган	12234	12512	2277	102.3	6014	6104	1208	101.5	6220	6408	1069	103
Бүрэгхангай	2726	2832	2888	103.9	1388	1459	1482	105.1	1338	1373	1406	102.6
Гурванбулаг	3133	3176	3219	101.4	1617	1644	1660	101.7	1516	1532	1559	101.1
Дашинчилэн	2803	2941	3037	104.9	1431	1492	1540	104.3	1372	1449	1497	105.6
Могод	2685	2701	2729	100.6	1375	1383	1394	100.6	1310	1318	1335	100.6
Орхон	3482	3584	3595	102.9	1865	1911	1913	102.5	1617	1673	1682	103.5
Рашаант	3141	3165	3215	100.8	1583	1602	1618	101.2	1558	1563	1597	100.3
Сайхан	3575	3648	3662	102	1816	1854	1871	102.1	1759	1794	1791	102
Сэлэнгэ	3207	3306	3332	103.1	1666	1723	1733	103.4	1541	1583	1599	102.7
Тэшиг	3495	3504	3563	100.3	1786	1782	1820	99.8	1709	1722	1743	100.8
Хангал	4548	4611	4705	101.4	2282	2302	2343	100.9	2266	2309	2362	101.9
Хишиг-Өндөр	3154	3156	3158	100.1	1592	1595	1592	100.2	1562	1561	1566	99.9
Хутаг-өндөр	4729	4835	4952	102.2	2432	2487	2546	102.3	2297	2348	2406	102.2
Нийт хүн ам	60014	61149	62027	101.9	30512	31077	31475	101.9	29502	30072	30552	101.9

## Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2017 он



## I.2 ХӨДӨЛМӨР

## Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2017 I		2018 I		2018 I % 2017 I	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	697	343	1004	489	144.0	142.6
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	865	433	673	343	77.8	79.2
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	24	12	14	6	58.3	50.0
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	11	4				
Уул уурхай олборлолт			1			
Боловсруулах үйлдвэр						
Цахилгаан, хий, уур, агааржуулалт						
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ						
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл						
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ			1			
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	7	5				
Боловсрол	1	1	1	1		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа						
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа						
Бусад	5	2	11	5		
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	697	343	1004	489	144.0	70.2
15-24	83	43	135	62	162.7	144.2
25-34	253	130	329	168	130.0	129.2
35-44	155	84	245	130	158.1	154.8
45-54	146	65	216	110	147.9	169.2
55-59	38	15	57	13	150.0	86.7
60+	22	6	22	6	100.0	100.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	697	343	1004	489	144.0	142.6
Магистр, доктор			3	2		
Дипломын болон бакалаврын дээд	151	91	166	93	109.9	102.2
Тусгай мэргэжлийн дунд	32	20	36	16	112.5	80.0
Техникийн болон мэргэжлийн	40	14	38	15	95.0	107.1
Бүрэн дунд	372	181	604	300	162.4	165.7
Суурь	73	28	119	52	163.0	185.7
Бага	23	7	26	10	113.0	142.9

## I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ

## Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2018 II 2017 II
	2017 II	2018 II	II	II	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4841	5558	685646.0	753442.2	109.9
Халамжийн тэтгэвэр	742	709	269635.3	270520.2	100.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2463	1723	251003.2	193818.3	77.2
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	1054	438	83048.0	29755.4	35.8
Ахмад настныг асарч буй иргэний	821	777	95490.1	98139.0	102.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	356	310	43129.6	40410.6	93.7
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	209	175	26572.8	22694.8	85.4
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	23	23	2762.7	2818.5	102.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	1636	3126	165007.5	289103.7	175.2
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	241	354	32345.3	73840.3	228.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	60	54	6550.0	21249.7	324.4
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	1335	1147	125493.9	139063.8	110.8
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ					
Хүнс тэжээл хөтөлбөр		1,571		54608.0	
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ			618.3	341.9	55.3

## I.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2015 II	2016 II	2017 II	2018 II	2018 II 2017 II
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	<b>1539</b>	<b>1801.5</b>	<b>1740.3</b>	<b>1457.6</b>	<b>83.8</b>
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	998.8	989.1	1044.9	1203.6	115.2
Тэтгэмжийн даатгалын сан	114.8	154.9	141.4	141	99.7
Эрүүл мэндийн даатгалын сан	326.7	517.5	430.5		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	71.6	93.7	90.6	79.4	87.6
Ажилгүйдлийн даатгалын сан	27.1	46.3	32.9	33.6	102.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	<b>4236.3</b>	<b>4836</b>	<b>5453.7</b>	<b>5609.8</b>	<b>102.9</b>
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	3742.9	4326.7	4840.9	5319.8	109.9
Тэтгэмжийн даатгалын сан	176.2	130.2	155.0	179.0	115.5
Эрүүл мэндийн даатгалын сан	257.1	304	338.9		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	32.8	37.7	56.4	54.5	96.6
Ажилгүйдлийн даатгалын сан	27.3	37.4	62.5	56.5	90.4

## I.4 ЭРҮҮЛ МЭНД

**Хүснэгт I.4.1** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр оноор

Үзүүлэлт	2015 II	2016 II	2017 II	2018 II	2017/2016
Амаржсан эхийн тоо	184	144	135	146	108%
Амьд төрсөн хүүхэд	183	145	137	148	108%
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	3	1	3	-	-
Гэрийн төрөлт	-	1	1	1	100%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	2	4	200%
Перинаталь эндэгдэл	5	2	2	4	200%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	16.4	6.9	14.6	27	185%

**Хүснэгт I.4.2** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2015 II	2016 II	2017 II	2018 II	2017/2016
Нийт гарсан халдварт өвчин	54	76	113	60	53%
Гэдэсний халдварт өвчин	3	0	3	2	67%
Амьсгалын замын халдварт өвчин	21	34	65	25	38%
Байгалын голомтот халдварт өвчин	0	0	0	1	-
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	24	34	39	25	64%
Арьсны халдварт өвчин	6	8	6	7	117%

## I.5 ГЭМТ ХЭРЭГ

**Хүснэгт I.4.1** Бүртгээгдсэн гэмт хэрэг, оноор, 2-р сарын байдлаар

Сум	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2018 I-II % 2017 I-II
Булган	15	22	21	17	16	94.1
Баян-Агт		1	1	1	2	200.0
Баяннуур	1	2	1	2	2	100.0
Бугат	5	5	3	4	6	150.0
Бүрэгхангай	4	7	5	3	1	33.3
Гурванбулаг	6	4	3	4	3	75.0
Дашинчилэн	1	4	3	1		0.0
Могод		2	6	1	2	200.0
Орхон	2	5	7	4	6	150.0
Рашаант	3	1	2	2	1	50.0
Сайхан	5	1	1	2	2	100.0
Сэлэнгэ	2	2	1	5	3	60.0
Тэшиг	2		1	1	2	0.0
Хангал	3		1	2	2	100.0
Хишиг-Өндөр	3	2	2	6		0.0
Хутаг-Өндөр	5	1	2	2	2	100.0
Хялганат	0	1	1	2	1	50.0
Бүгд	57	60	61	59	51	86.4

**Хүснэгт 1.4.2 Хулгайн гэмт хэрэг, сумаар, оноор, 2-р сарын байдлаар**

Сум	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II
Булган	4	4	6	6	8
Баян-Агт					1
Баяннуур	1	2		2	
Бугат	2	2	2	2	
Бүрэгхангай	1	5	1	1	
Гурванбулаг	4	1		2	
Дашинчилэн		4	2		
Могод			2	1	1
Орхон		4	3	2	2
Рашаант	3	1	1	1	
Сайхан	4		1	2	1
Сэлэнгэ	2			1	
Тэшиг					1
Хангал					
Хишиг-Өндөр	3		1	2	
Хутаг-Өндөр	1			1	
Хялганат					
Бүгд	25	23	19	23	14

**Хүснэгт 1.4.3 Сумдын хэргийн илрүүлэлт 2017 оны 2-р сарын байдлаар**

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг	
	2017 I-II	2018 I-II	2017 I-II	2018 I-II
Булган	5	10	3	3
Баян-Агт		2		1
Баяннуур	1	1	1	1
Бугат	1	5	1	1
Бүрэгхангай	1			
Гурванбулаг	2	1	2	1
Дашинчилэн				
Могод	1	1	1	1
Орхон	2	6	2	
Рашаант	1			
Сайхан	3	1	2	
Сэлэнгэ	2	1	2	1
Тэшиг		2		1
Хангал	1	2	1	
Хишиг-Өндөр	3		3	
Хутаг-Өндөр	1	1		
Хялганат	1	1	1	
Бүгд		34		10

**Хүснэгт I.4.4 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, оноор, 2-р сарын байдлаар**

Үзүүлэлт	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2018 II% 2017 II
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	132.6	145.0	144.8	128.4	68.7	53.5
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	89.4	74.3	84.6	76.7	41.6	54.2
Нөхөн төлүүлэлтийн хувь	67.4	51.2	58.4	59.7	60.6	101.4

## II.3 ҮНЭ

**Хүснэгт II.3.1 Хэрэглээний үнийн ерөнхий индекс, барааны бүлгээр**

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	Жин	2018 II 2017 II	2018 II 2017 XII	2018 II 2018 I
Ерөнхий индекс	100.0	103.2	101.8	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	106.4	103.9	102.4
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.5	101.6	100.0
Хувцас, бөс бараа гутал	16.1	98.4	100.6	100.4
Орон сууц, ус цахилгаан, түлш	12.3	102.0	100.2	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.7	101.9	100.2	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	101.5	100.2	100.0
Тээвэр	12.2	109.3	105.1	104.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.6	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.1	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	109.5	102.2	100.0

**Хүснэгт II.3.2 Хүнсний гол нэр төрлийн барааны 7 хоногийн ажиглалт 2018 оны 2-р сарын сүүлийн 7 хоног, 2017 оны 2-р сарын сүүлийн 7 хоногтой харьцуулсан**

Барааны нэр төрөл		2017 II/22	2018 II/28	2017 II/22 2018 II/28
"Алтан тариа" дээд, савласан	гурил	1500	1500	100.0
гурил	I зэрэг, задгай	1300	1300	100.0
Орон нутгийн	"Хангай" 1-р	1100	1100	100.0
гурил	гурил"			
	"Орхон мандал"	2500	2500	100.0
	1-р гурил			
Талх "Ундрах" аймгийн үйлвэр		2500	2500	100.0
Цагаан будаа		2000	2000	100.0
Элсэн чихэр		2700	2700	100.0
Сүү	Задгай	3700	4300	116.2
	"Цэвэр сүү"	6000	7000	116.7

Ургамлын тос, "Кларина"		5000	5000	100.0
Мах	Үхрийн	4500	6000	133.3
	Хонины	3500	3500	100.0
	Адууны	700	1000	142.9
	Ямааны	800	1500	187.5
Ногоо	Төмс /монгол/	800	1500	187.5
	Лууван /монгол/	800	1500	187.5
	Байцаа /монгол/	3000	2000	66.7
	Манжин /монгол/	1500	1500	100
	Сонгино /монгол/	500	400	80.0
	Сонгино /хятад/	1500	1500	100
	Сармис	500	400	80.0


### Хүснэгт II.3.3 Хүнсний гол нэр төрлийн барааны ажиглалт, оноор, 2-р сарын байдлаар

Барааны нэр төрөл		Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018	2018 II 2017 II
"Алтан тариа"	I зэрэг	кг	1200	1400	1283	1333	1333	100.0
гурил /задгай/	II зэрэг	кг	700	900	1000	1000	1100	110.0
Будаа	Цагаан	кг	2300	2400	2466	2517	2467	98.0
	Шар	кг	1700	1900	1900	1900	1900	100.0
Элсэн чихэр		кг	1800	1700	1666	2466	2217	89.9
Хонины мах	ястай	кг	6000	5500	4000	5000	5000	100.0
	цул	кг	6000	5500	4000	5000	5000	100.0
Үхрийн мах	ястай	кг	7000	7000	5500	5500	7500	136.4
	цул	кг	7000	7000	5500	6000	7500	125.0
Адууны мах		кг	6000	5500	4000	4000	6000	150.0
Ямааны мах		кг	4500	4500	3500	3500	4000	114.3
Сүү	задгай	л	1500	2000	2000	2000	2000	100.0
	"Цэвэр сүү"	л	2300	2750	2633	2633	2683	101.9
Байцаа	монгол	кг	1000	1000	1000	800	1500	187.5
Лууван	монгол	кг	1000	1000	1800	800	1500	187.5
Манжин	монгол	кг	1500	1500	2000	800	1500	187.5
Төмс	монгол	кг	800	1200	1000	700	1000	142.9
Сонгино	хятад	кг	1500	1500	1500	1500	1375	91.7
Сармис, булцуу		кг	300	300	350	500	400	80.0
Ургамлын тос		л	3500	3600	3566	3866	3667	94.9
Өндөг		ш	420	350	300	350	333	95.1
Талх "Ундрах" орон нутгийн		ш	750	900	1066	1100	1067	97.0

**Хүснэгт II.3.4 Нэг литр шатахууны үнэ, 2018 оны 2-р сарын байдлаар**

ШТС	АИ 95	АИ 92	АИ 80	Дезил түлш	Газ
Шунхлай	0	1765	1630	2050	0
Тэс	0	1790	1680	200	0
Магнай трейд	0	1770	1630	2050	0
Петровис	2090	1770	1630	2050	0
Гиг газ	0	0	0	0	1250


**Зураг II.3.1 Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2018 оны 2-р сарын байдлаар**



**Нэг кг хонины махны үнэ, төгрөг**



**Нэг кг үхрийн махны үнэ, төгрөг**



**Хүснэгт II.3.5 Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, 2017, 2018 оны 1-р сарын байдлаар, төгрөгөөр /2-р сард үнийн судалгаа аваагүй/**

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2017-I	2018-I
1	Гахайн мах	кг	6000	7000
2	Тахиан мах	кг	-	-
3	Цагаан ноолуур	кг	-	50000
4	Бор ноолуур	кг	-	50000
5	Адууны шир	ш	30000	19500
6	Адууны дэл	ш	4000	4500
7	Адууны сүүл	ш	4000	5500
8	Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй шир	ш	20000	22500
9	Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй шир	ш	30000	35000
10	Хонины ноостой нэхий	ш	1750	5250
11	Хонины ноосгүй нэхий	ш	-	-
12	Ямааны ноолуургүй арьс	ш	13500	20000

**Хүснэгт II.3.6 Тэмээний үнэ, сумаар, мян.төг жил бүрийн 2-р сарын байдлаар**

Сумын нэр	Нас гүйцсэн тэмээ				Өсвөр насны тэмээ			
	Ат		Ингэ		Эр		Эм	
	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I
Баяннуур	767	782	630	714	520	565	517	550
Бүрэгхангай	891	900	791	800	705	450	705	450
Дашинчилэн	708	732	608	595	288	291	288	291
Могод	900	-	850	-	450	-	420	-

**Хүснэгт II.3.7 Адууны үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 2-р сарын байдлаар**

Сумын нэр	Нас гүйцсэн адуу				Өсвөр насны адуу			
	Морь		Гүү		Эр		Эм	
	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I
Булган	700	700	700	700	500	464	500	455
Баян-Агт	400	-	400	-	330	291	330	291
Баяннуур	917	555	733	495	346	360	344	355
Бугат	797	805	800	764	667	627	667	627
Бүрэгхангай	654	680	650	640	542	450	513	450
Гурван булаг	605	560	514	480	350	364	338	329
Дашинчилэн	578	573	467	448	334	309	325	309
Могод	742	500	671	475	288	305	288	295
Орхон	600	573	550	550	350	355	348	325
Рашаант	538	568	500	495	364	336	346	336
Сайхан	538	632	467	600	258	427	263	427
Сэлэнгэ	650	700	575	600	375	400	379	400
Тэшиг	546	536	546	536	396	395	396	395
Хангал	796	830	721	795	458	477	463	478
Хишиг-өндөр	609	536	565	455	370	273	308	270
Хутаг-Өндөр	471	430	508	500	329	295	300	295

**Хүснэгт II.3.8 Үхрийн үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 2-р сарын байдлаар**

Сумын нэр	Нас гүйцсэн үхэр				Өсвөр насны үхэр			
	Эр		Эм		Эр		Эм	
	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I
Булган	783	673	750	618	629	445	621	482
Баян-Агт	754	600	664	600	458	425	458	400
Баяннуур	1008	825	958	523	500	418	492	370
Бугат	1003	927	900	732	623	590	615	555
Бүрэгхангай	838	740	717	690	567	500	573	505
Гурван булаг	786	683	661	564	560	514	495	480
Дашинчилэн	649	692	540	577	452	435	437	435
Могод	775	705	700	685	508	478	508	478
Орхон	600	723	550	609	496	432	492	386
Рашаант	1063	995	742	754	679	583	585	449
Сайхан	838	832	779	755	504	555	504	555
Сэлэнгэ	1300	1027	983	1118	583	555	650	664
Тэшиг	688	700	592	600	379	400	358	355

Хангал	796	836	775	782	458	505	467	491
Хишиг-өндөр	836	782	635	609	528	409	504	364
Хутаг-Өндөр	933	744	788	622	442	355	442	345

**Хүснэгт II.3.9 Хонь ямааны үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 2-р сарын байдлаар**

Сумын нэр	Нас гүйцсэн хонины үнэ				Нас гүйцсэн ямааны үнэ			
	Эр		Эм		Эр		Эм	
	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I	2017 I	2018 I
Булган	133	119	102	101	93	88	82	77
Баян-Агт	115	105	78	84	80	76	60	58
Баяннуур	98	93	60	66	78	74	49	49
Бугат	142	117	128	101	122	83	106	76
Бүрэгхангай	101	108	76	88	75	78	62	67
Гурван булаг	113	105	74	70	81	78	50	50
Дашинчилэн	100	93	56	58	73	78	40	39
Могод	144	108	85	80	78	70	66	69
Орхон	100	133	80	93	89	77	80	69
Рашаант	127	119	69	80	88	80	41	46
Сайхан	99	100	83	75	82	84	63	58
Сэлэнгэ	99	80	118	80	89	70	79	60
Тэшиг	125	116	80	79	80	80	61	52
Хангал	151	149	121	118	95	98	82	90
Хишиг-өндөр	122	93	80	69	84	75	54	50
Хутаг-Өндөр	120	146	98	85	82	82	64	52

**Хүснэгт II.3.10 Малын зах зээлийн дундаж үнэ, мян.төгрөг, 2-р сарын байдлаар**

Нэр	2017-I	2018-I	2018 I / 2017 I	Нэр	2017-I	2018-I	2018 I / 2017 I
<b>Буур</b>	850	900	106%	Шүдлэн гунж	494	394	80%
Нас гүйцсэн ат	767	950	124%	Эр тугал	186	151	81%
Нас гүйцсэн ингэ	683	867	127%	Эм тугал	191	147	77%
Эр шилбэ	417	517	124%	<b>Хуц</b>	156	140	90%
Эм шилбэ	417	517	124%	Эр хонь	110	100	91%
Эр ботго	125	233	186%	Эм хонь	83	75	90%
Эм ботго	125	233	186%	Эр төлөг	61	51	84%
<b>Азарга</b>	916	852	93%	Эм төлөг	59	48	81%
Соёолон үрээ	602	597	99%	Эр хурга	30	25	83%
Соёолон гүү	567	553	98%	Эм хурга	30	25	83%
Шүдлэн үрээ	385	377	98%	<b>Ухна</b>	117	109	93%
Шүдлэн байдас	375	377	101%	Эр ямаа	79	75	95%
Эр унага	176	150	85%	Эм ямаа	63	54	86%
Эм унага	178	152	85%	Эр борлон	42	36	86%
<b>Бух</b>	867	808	93%	Эм борлон	41	35	85%
Хязаалан шар	814	705	87%	Эр ишиг	23	20	87%
Хязаалан дөнж	661	623	94%	Эм ишиг	23	20	87%
Шүдлэн эр үхэр	512	414	81%				

## II.6 АЖ ҮЙЛДВЭР

**Хүснэгт II.6.1 Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, жил бүрийн 2-р сарын байдлаар**

Салбараар	Нийт бүтээгдэхүүн (оны үнээр, мян.төг)		
	2017 II	2018 II	2018 II % 2017 II
Нийт дүн	2079478.5	1573828.6	75.7
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>39546</b>	<b>284460.5</b>	<b>719.3</b>
Нүүрс олборлолт	39546	284460.5	719.3
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>1202870.5</b>	<b>361106.6</b>	<b>30.0</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	1165737.5	348731.6	29.9
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	5577.5	133273.6	2389.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0	16127	0.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	1062335	45827.5	4.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	97825	153503.5	156.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	16133	5475	33.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	21000	6900	32.9
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	837062	928261.5	110.9
<b>Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл</b>	<b>837062</b>	<b>928261.5</b>	<b>110.9</b>

**Хүснэгт II.6.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, салбараар, 2-р сарын байдлаар**

Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
		Биет хэмжээ			Үнийн дүн / мян.төг/		
		2017 I-II	2018 1-II	2018 II % 2017 II	2017 I-II	2018 1-II	2018 II % 2017 II
А	Б	1	2		3	4	
Чулуун нүүрс	мян.тн	0.8	6.9	862.5	39546	284460.5	719.3
Бог будаа	тн	0.7	0.39	55.7	5600	3120	55.7
Дулааны эрчим хүч	мян.Гкал	6	3	50.0	180250.5	232633.3	129.1
мах	тн	0	10		0	49600	0.0
Хиамны зүйл	тн	0	9		0	35200	0.0
Утсан, чанасан болон бусад боловсруулалт хийсэн ма	тн	0	3		0	10500	0.0
Дүфү	тн	0	1		0	3800	0.0
Жимсний чанамал	тн	0.9	1.66	184.4	4200	7867	187.3
<b>Айраг</b>	мян.л	0	0.65		0	7753	0.0
Гурил I зэрэг	тн	1.1	1.8	163.6	2750	5400	196.4
Гурил II зэрэг	тн	0	0.05		250	800	320.0
Арвайн гурил	тн	0	3.6		0	14762	0.0
Багсармал болон бусад малын тэжээл	тн	619.1	85.2	13.8	435550	72441.3	16.6
Хивэг	тн	16.2	1.2	7.4	8426	735	8.7
Нарийн боов	тн	12	7.855	65.5	11450	7644.2	66.8
Бялуу	тн	14.2	0	0.0	3819	0	0.0
Талх	тн	181.8	2.3	1.3	60619	931.6	1.5
Эмчилгээний цай	кг	10	26	260.0	16044	41500	258.7
Бусад цай	кг	0	0.094		0	2303	0.0
Банш, бууз, хуушуур	тн	15.7	11	70.1	43200	57600	133.3
Энержи дринк	мян.л	0	10		0	8520	0.0
Ноосон майк, путболька	ш	30	180	600.0	750	4500	600.0
Ноосон алчуур, нөмрөг	ш	24.7	38	153.8	1100	1700	154.5
Ноолууран цамц	ш	0	0.33		0	1413.6	0.0
Оёмол хүрэм	ш	0	0.12		375	1375	366.7
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	0	5		0	500	0.0
Ажлын хувцас	ш	0	3		0	135	0.0
Монгол дээл, тэрлэг	ш	100	0	0.0	1500	0	0.0
Хүүхдийн платъе	ш	0	10		0	350	0.0
Өвлийн малгай	ш	0	15		0	225	0.0
Түгээсэн цэвэр ус	мян.м3	0	2		0	520	0.0

## II.14 МАЛ АЖ АХУЙ

**Хүснэгт II.14.1 Малын тоо 2017 он**

Сумын нэр	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Булган	63131	0	5428	8697	29958	19048
Баянагт	295555	18	18249	21579	158332	97377
Баяннуур	111182	302	6471	8591	57210	38608
Бугат	110934	3	9976	18442	50157	32356
Бүрэгхангай	269423	134	18158	20211	141934	88986
Гурванбулаг	320883	159	20721	12341	180072	107590
Дашинчилэн	226014	182	14104	12189	129661	69878
Могод	310228	47	28962	19857	192383	68979
Орхон	317468	106	28232	27716	152932	108482
Рашаант	189145	296	13354	9044	102898	63553
Сайхан	351200	87	38235	19696	216585	76597
Сэлэнгэ	90796		7895	19481	38170	25250
Тэшиг	82404		7362	20594	31306	23142
Хангал	91441	2	6252	18607	35647	30933
Хишиг-Өндөр	239485		20957	16185	128236	74107
Хутаг-Өндөр	292344	24	17506	30661	148930	95223
Бүгд	3361633	1360	261862	283891	1794411	1020109

**Хүснэгт II.14.8 Зүй бусаар хорогдсон том мал, төрлөөр, оноор**

Малын төрөл	Хорогдсон том мал, толгой			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2016 I-II	2017 I-II	2018 I-II
Бүгд	11633	6423	21545	0.4	0.2	0.6
Адуу	1015	720	2836	0.4	0.3	1.0
Үхэр	1511	691	5546	0.6	0.2	1.9
Тэмээ	0	0	0	0.0	0.0	0.0
Хонь	4475	2624	6321	0.3	0.2	0.3
Ямаа	4632	2388	6842	0.5	0.2	0.6

**Хүснэгт II.14.9 Хорогдсон том мал, төрлөөр, сумаар, 2018 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	273	27	103	0	67	76	0.4	0.5	1.2	0	0.2	0.4
Баян-Агт	1221	105	347	0	361	408	0.4	0.6	1.6	0	0.2	0.4
Баяннуур	424	61	87	0	128	148	0.4	0.9	1	0	0.2	0.4
Бугат	831	116	281	0	194	240	0.7	1.2	1.5	0	0.4	0.7
Бүрэгхангай	3148	508	756	0	881	1003	1.2	2.8	3.7	0	0.6	1.1
Гурван булаг	1361	176	247	0	384	554	0.4	0.8	2	0	0.2	0.5
Дашинчилэн	879	172	129	0	298	280	0.4	1.2	1.1	0	0.2	0.4
Могод	4490	677	1591	0	1168	1054	1.4	2.3	8	0	0.6	1.5
Орхон	3923	358	740	0	1324	1501	1.2	1.3	2.7	0	0.9	1.4
Рашаант	1435	121	119	0	538	657	0.8	0.9	1.3	0	0.5	1
Сайхан	100	0	15	0	50	35	0	0	0.1	0	0	0
Сэлэнгэ	192	21	32	0	68	71	0.2	0.3	0.2	0	0.2	0.3
Тэшиг	212	24	46	0	63	79	0.3	0.3	0.2	0	0.2	0.3
Хангал	149	10	83	0	21	35	0.2	0	0.4	0	0.1	0
Хишиг-өндөр	2890	453	962	0	776	699	2.3	2.2	5.9	0	0.6	0.9
Хутаг-Өндөр	17	7	8	0	0	2	1.2	0	0	0	0	0
Бүгд	21545	2836	5546	0	6321	6842	0.6	0	1.9	0.0	0.3	0.6

**Хүснэгт II.14.9 Өвчнөөр хорогдсон том мал, сумаар, 2018 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	62	0	62	0	0	0	22.7	0	60.2	0	0	0
Баян-Агт	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0.0	0.0
Баяннуур	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Бүрэгхангай	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0.0	0.0
Гурван булаг	57	0	49	0	4	4	4.2	0	19.8	0	1	0.7
Дашинчилэн	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Могод	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Орхон	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Сайхан	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0.0	0
Сэлэнгэ	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Тэшиг	3	0	0	0	2	1	1.4	0	0	0	3.2	1.3
Хангал	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0.0	0.0
Хишиг-өндөр	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0.0	0.0
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0	0.0	0	0	0	0	0
Бүгд	122	0	111	0	6	5	0.6	0.0	2.0	0	0.1	0.1

**Хүснэгт II.14.10 Хорогдсон хээлтээгч, сумаар, 2018 оны 2-р сарын байдлаар**

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
Баян-Агт	8	0	0	0	3	5	0.7	0.0	0.0	0	0.8	1.2
Баяннуур	106	13	26	0	30	37	25.0	21.3	29.9	0	23.4	25.0
Бугат	231	31	59	0	66	75	27.8	26.7	21.0	0	34.0	31.3
Бүрэгхангай	132	13	24	0	51	44	4.2	2.6	3.2	0	5.8	4.4
Гурван булаг	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
Дашинчилэн	127	18	24	0	65	20	14.4	10.5	18.6	0	21.8	7.1
Могод	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
Орхон	550	29	105	0	230	186	14.0	8.1	14.2	0	17.4	12.4
Рашаант	0	0	0	0	0	0	0	0.0	0.0	0	0.0	0.0
Сайхан	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
Сэлэнгэ	149	11	27	0	46	65	77.6	52.4	84.4	0	67.6	91.5
Тэшиг	17	4	3	0	5	5	8.0	16.7	6.5	0	7.9	6.3
Хангал	31	0	18	0	5	8	20.8	0.0	21.7	0	23.8	22.9
Хишиг-өндөр	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0	0.0	0.0	0.0	0	0.0	0.0
40674	1351	119	286	0	501	445	6.3	4.2	5.2	-	7.9	6.5

## Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ?

**[www.1212.mn](http://www.1212.mn)** Статистикийн мэдээллийн нэгдсэн сан  
**[bulgan.nso.mn](http://bulgan.nso.mn)** Хэлтсийн вэб сайт



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



[www.nso.mn](http://www.nso.mn) сайтад бүртгүүлснээр цахим шуудангаар тогтмол авч болно.



[www.facebook.com/pages/ Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/pages/Статистик-Мэдээлэл)  
[www.facebook.com/pages/Булган аймгийн засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс](http://www.facebook.com/pages/Булган-аймгийн-засаг-даргын-дэргэдэх-статистикийн-хэлтэс)

[www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)



**1900-1212**

1 минут = 200 төгрөг

**70342766**









СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН  
[WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

Хаяг:	Address
Монгол улс, Булган аймаг, Булган сум, Засаг даргын тамгын газар, 105, 106 тоот Статистикийн хэлтэс	Statistics office, №105, 106 Governers office Bulgan sum, Bulgan aimag, Mongolia
Утас:	Phone:
70342766	70342766
И-мэйл:	E-mail:
<a href="mailto:bulgan@nso.mn">bulgan@nso.mn</a>	<a href="mailto:bulgan@nso.mn">bulgan@nso.mn</a>
вэб:	Web:
<a href="http://www.bulgan.nso.mn">www.bulgan.nso.mn</a>	<a href="http://www.bulgan.nso.mn">www.bulgan.nso.mn</a>